

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 3 дугаар
сарын 24-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Г “Эрдэнэст” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг
түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4 дэх заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Эрдэнэст” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 1 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-д, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН